Есөн хүслийн
ЭБЭХЭ ГЭР БОЛОВСРОЛ

ХАНИЙН ХҮСЭЛ

ЭБЭХЭ СОЁЛ

Билиг №1

Өнөөдөр юу мэдэж авах вэ?

- *Эбэхэ тогтолцоо Хабул хааны үеэс хэрхэн үүссэн бэ?*
- *Монгол гэр бүлийн өнөөгийн байдал ямар байна вэ?*
- *Гэр бүл нийхэмийн суурь болдгийн учир юу вэ?*
- *Гэрлэхийн өмнө юу мэдэж, юуг шалгах ёстой вэ?*

ХОС: ГЭРЛЭХИЙН ӨМНӨХ ОЙЛГОЛТ

Эбэхэ нарын асуултууд:

1. Хоёулаа ижил үнэт зүйлтэй юу?
2. Маргалдахад хэрхэн ханддаг вэ?
3. Мөнгөний талаар ил тод ярьж чаддаг уу?
4. Гэр бүлийн тухай ижил мөрөөдөлтэй юу?
5. Дөрвөн улиралд хамт байж туршсан уу?

Гэр бүл яагаад нийхэмийн суурь вэ?

Бүлт гэдэг нь хүн нийхэмийн хамгийн бага нэгж юм.

Улс үндэстний эв нэгдэл, соёл иргэншил, удмын сангийн аюулгүй байдлын үндэс нь гэр бүл.

Тиймээс гэр бүлийн боловсрол, нийхэмийн ёс суртахууныг төрөөс Эбэхэ нарт даатгадаг байсан.

Хамаг Монголын үеийн гэр бүл

Эбэхэ соёлын сэргэлт

Хамаг Монголын Хабул ханыг хаан ширээнд сууж төрөө төвхнүүлж эхлэхэд Монгол түмний уламжлалт Эбэхэ соёл тасарсан байсан тул Олхонуудаас 2, Хэрэйдээс 1 Эбэхэ хосыг л олж чадсан. Иймээс Хабула хан 3 гэр бүлийн Эбэхэд залуу хосуудыг өгч "Чоносын отог болгоноос сурлага дүүргэ" гэж ерөөснөөр бүлийн соёл дахин эхэлсэн түүхтэй.

Ингээд тусгай Эбэхэ гэдэг мэргэшилтэй, онол сургалт буюу чадамж нь үгүй ч ухагдахуун нь байдаг залуу үеийнхэн гарч ирсэн. Энэ залуу үеийнхэн тухайн цаг үеийнхнийхээ бүл тогтворжилтыг чадлынхаа хэрээр удирдаж, амжилт үүсгэж байснаар төр нийхэмийн асар хүнд цаг үеүд, байгалийн гамшгийн хэцүү нөхцөлд улс сэрэхүйн бат үндсийг бий болгож байсан. Учир нь тэдний тэмүүлэл төсөөлөл зөв байсантай уялдан гэр бүлд тохиолдох асуудлыг даван туулах чин хүсэл, чигч жаяг бий болчихсон гэсэн үг юм.

Энэ үеийн гэр бүлийн боловсрол

Харин яг одоо бидний амьдарч буй энэ үеийг хүртэл Эбэхэ соёл хэдэн зуун жилээр тасарч, төрийн бодлогод энэ талаар уламжлан авч үлдсэн зүйл бараг үгүй болсон. Зөвхөн зарим гэр бүлүүдэд эмээ өвөөгаас уламжлан ирсэн аман яриand мөн чанар нь бүдгэрэн ёс төдий үлдсэн зүйл л байгаа. Тийм ч учраас бэр гуйх, охидын инж, ханиа хэрхэн шинжих, хайр, ханилах, эцэг эх хамт байж хүүхдээ өсгөснөөр хүүхдийн заяанд болон эцэг эхийн амжилтанд хүүхэд өсгөлт хэрхэн нөлөөлдөг гээд уламжлалт гэр бүлийн соёлоо гээжээ.

Иймээс “хайр” гэдгийг ердөө хараад таалагдсанаар өнгөц ойлгох, “хайртай л бол” хамт амьдарна гэх явцуу бодлоосоо болж амьдралаараа хохирох, хүүхэд өнчрөх, өрх толгойлсон ганц бие эцэг эхчүүд олшрох гээд цаашилбал нийгмийн бусармаг үйлдлүүд гарах үндэс болж байна.

Монгол гэр бүлийн өнөөгийн байдал:



Гэрлэлт буурч байна

2019 оныг 2024 онтой харьцуулахад бүртгэгдсэн гэрлэлт 29%-иар буурсан



Өдөр бүр 10 гэр бүл салж байна

гэр бүл цуцлалт 5%-иар өссөн байна.



Гэр бүлийн маргааны гол шалтгаанууд:

- 29.2% — үзэл бодлын зөрчил
- 24.4% — согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх
- 22.8% — харилцан ойлголцол дутмаг
- 21.5% — мөнгө, санхүүгийн хомсдол

“Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт–2025” судалгааны тайлангаас

Яагаад одоо Эбэхэ соёлыг дэлгэрүүлэх шаардлагатай вэ?

Хүн хосоо сонгож байгаа мэт боловч үнэндээ хосын харилцааны суурь нь бага наснаас бүрэлддэг. Хүн мэндлээд эцэг эхээсээ хайрлаж, хайрлуулахын утгыг сурч, өсөж бойждог. Тэр суурь нь хожим өөрийн хосын харилцаанд илэрдэг. Өөрөөр хэлбэл хосын харилцаа хуримын өдөр эхэлдэггүй.

Хүний хүмүүжил, хайр, харилцааны ойлголт бага наснаас эхэлж төлөвшдөг.
Тиймээс Эбэхэ соёлын зорилго нь зөвхөн “сайн хань сонгох”-ыг заах биш, харин хүн өөрөө: *хайрлагдаж сурах* → *хайрлаж сурах* → *хосоо ойлгох* → *хоёр бүлээ нийцүүлэх* → *өөрийн гололтыг бүтээх* гэсэн замыг ухамсартайгаар туулахад нь туслах явдал юм.

Хосын харилцаа нь зөвхөн хоёр хүний асуудал биш

Хоёр хүн ханилахад зөвхөн “**би чамд хайртай**” гэдэг үг хангалтгүй.
Миний гэр бүл + чиний гэр бүл → бидний шинэ бүл гэсэн шинэ харилцааны орон зай үүснэ.
Иймээс Эбэхэ соёл нь хүүхдэд гэр бүлийг зөвхөн “аав, ээж, хүүхэд” гэж ойлгуулахаас цааш бүл, голомт, хос, үргэлжлэл гэсэн холбоог ойлгуулдаг.

Эбэхэ соёлд:

Хүн:

- Хайрлуулахыг хүсдэг. Гэхдээ хайрлуулж чаддаг байх хэрэгтэй
- Хайрлахыг хүсдэг. Гэхдээ хэрхэн хайрлах ухаантай байх хэрэгтэй.

Тиймээс хүүхдэд зөвхөн “*хайр бол сайхан зүйл*” гэж хэлэх биш, “*би хайр авахдаа ямар хүн байх вэ, би хайр өгөхдөө ямар хүн байх вэ?*” гэдгийг өөрөөр нь эргэцүүлүүлэх нь чухал гэж үздэг.

Хосын сонголтод хүний өссөн хүмүүжил нөлөөлдөг

Хүүхдийн өнөөдрийн хүмүүжил бол зөвхөн өнөөдрийн зан төлөвийн асуудал биш. Ирээдүйн харилцааных нь суурь юм. Өөрөөр хэлбэл:

- Өнөөдөр хүүхдэд хайр хэрхэн үзүүлж байна вэ?
- Өнөөдөр хүүхэд бусдыг хэрхэн сонсож сурч байна вэ?
- Өнөөдөр хүүхэд зөрчлийг хэрхэн шийдэж сурч байна вэ?
- Өнөөдөр хүүхэд өөрийгөө хэрхэн үнэлж байна вэ?

гэдэг нь хожмын амьдралын харилцаанд ач холбогдолтой. Иймээс Эбэхэ соёлын боловсролыг хосын асуудал гарсны дараа биш, түүнээс олон жилийн өмнө эхлүүлэх шаардлагатай.

ХАЙР → ХОС → ХОЁР БҮЛ → ШИНЭ ГОЛОМТ

“Хоёр хүн” биш, “хоёр бүл”-ийг нийцүүлэх ухаан

Гэр бүл болж ханилан амьдрахыг зөвхөн:
“Би түүнд хайртай учраас сууна” гэж ойлгохоос,
“*Бид хоёр бие биенээ сонгож байна. Үүний хамт хоёр бүлээ хүндэтгэж, шинэ голомтын хариуцлагыг үүрч байна*” гэсэн ухамсарт хүргэх хэрэгтэй.

Гэр бүл өөрөө аяндаа бүтдэг зүйл биш.

Гэр бүлийн бат бөх байдлыг зөвхөн гэр бүл болсны дараа ярих биш, гэр бүл болохоос өмнө хүнийг хайрлах, хайрлуулах, харилцах, хүндэтгэх, хариуцлага хүлээх ухаанд сургах хэрэгтэй.

Анхаарал хандуулсанд баярлалаа

Гэр бүл бүр бүтэн жаргалтай байх болтухай